# ХОС ХӨЛӨГ ХХК

# БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН 2025



# АГУУЛГА

1. **Төслийн танилцуулга**
2. **Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт**
3. **Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт, хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан**
   - **3.1. Байгаль орчны аудит**
   - **3.2. Удирдлага зохион байгуулалт**
   - **3.3. Усан орчны менежмент тайлан**
   - **3.4. БОННҮ, БОМТ, ОХШХ хэрэгжилт**
   - **3.5. Биологийн олон янз байдал, нөхөн сэргээлт менежментийн тайлан**
   - **3.6. Агаар орчны менежментийн тайлан**
   - **3.7. Хог хаягдлын менжементийн тайлан**
   - **3.8. ХАБЭА**
   - **3.9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зарцуулсан зардал**
   - **3.10. Бусад ажил**

## НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. **Төслийн нэр**: “Төмөр замын ачиж буулгах” төсөл

1.2. **Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага**:

“Хос хөлөг ХХК Регистрийн дугаар: 5353017

Хаяг: Говьсүмбэр аймаг, Сүмбэр сумын 1-р баг Төмөр замын баруун талд

**ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

**Төслийн байршил** нь Говь-Сүмбэр аймгийн Сүмбэр сумын нутагт Улаанбаатар хотоос Улаанбаатар хотоос урагш 220 км, Сүмбэр сумаас баруун урд зүгт 23 км, Чойр хотоос баруун хойд зүгт 17 км зайд оршино. Төсөл хэрэгжих талбайн зүүн талаар Монгол улсын босоо тэнхлэгийн авто зам, төмөр зам дайран өнгөрнө. “Хос хөлөг” ХХК нь “Чойрложистик” ХХК-ийн 100 хувийн хувьцаа эзэмшигч бөгөөд менежментийн гэрээний дагуу “Төмөр замын ачиж буулгах терминал” төслийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан явуулдаг ба Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутаг дэвсгэрт Засаг даргын 2015 оны 04 дүгээр сарын13-ний өдрийн А/114 тоот шийдвэрийн дагуу Сүмбэр сумын 1-р баг Төмөр замын баруун талд 180000 м2 газрыг 13 жилийн хугацаатай үйлдвэрлэлийн зориулалтаар эзэмшихээр гэрчилгээ авсан байна.

**Үйлдвэрлэлийн хүчин чадал:**

Эзэмшил талбайд “Хос хөлөг” ХХК-ийн нь захиргаа удирдлагын байр /оффис, цайны газар, ажилчдын амрах байр, харуул хамгаалалтын байр болон талбайн үйл ажиллагаа хангах гүний худаг, бетон хашаа зэргийг барьж байгуулсан. Ачилт буулгалтын талбай нь жилд 1 сая тонн нунтаг ачаа ачиж буулгах хүчин чадалтай бөгөөд нийт 18,2 га талбайн 12 болон 6 га талбайд нэг дор 100 вагонд ачилт буулгалт хийх юм. Энэ зорилгоор төслийн талбайд 2,4 км төмөр замтай, 150 тн авто болон вагон пүүтэй, 24 цагийн харуул хамгаалалттай, гааль болон МХГ зэрэг төр захиргааны ажилчдын оффисын барилгатай. Дэд бүтэц, инженер хангамж: “Хос хөлөг” ХХК нь Улаанбаатар хотоос 230 км зайд байрлах бөгөөд тухайн бүс нутагт дэд бүтцийн хөгжил сайтай бүс нутагт хамаарагдах ба олон улсын төмөр зам, авто замын сүлжээ, цахилгаан эрчим хүч болон өндөр хурдны шилэн кабелд бүрэн холбогдоод байна. Ус хангамж: Талбайн өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглагдаж буй техник хэрэгслийн хэрэгцээний усыг талбайн хашаанд байрлах гүний худгаас хангана. Ачилт буулгалтын талбайд ажиллаж буй ажилчдын унд ахуйн зориулалтаар ашиглах усыг орон нутгийн суурин гүний худгуудаас зөөврөөр татан авч ашиглана. Дулаан хангамж: Талбайн үндсэн тоног төхөөрөмжүүд нь гадаа буюу ил задгай талбайд байрлах тул өвлийн улиралд дулааны хэрэглээ байхгүй болно. Харин дагалдах байгууламж болох оффис, пүүний болон болон харуулын байрны халаалтыг хүйтний улиралд цахилгаан халаагуураар шийдсэн болно. Цаашид нам даралтын зуух ашиглалтад оруулахаар төлөвлөж байна. Цахилгаан хангамж: “Хос хөлөг” ХХК нь эрчим хүчний хэрэглээг Төмөр замын цахилгаан шугам сүлжээнээс 6 кВ-н цахилгаан дамжуулах агаарын шугамаар хүчдэл авч ашигладаг. Талбайд суурилуулсан үндсэн тоног төхөөрөмжүүдийн хэрэглээнд тулгуурлан КТПН 400/6 бууруулах дэд трансформаторыг суурилуулсан. Вагон пүү, авто пүү, оффисын зориулалтаар 5 байр, талбайн бүтэн гэрэлтүүлэг зэрэгт цахилгаан хангамжийг ашиглаж байна. Зам, харилцаа холбоо: Говьсүмбэр аймгийн бүх сумдын нутгаар Москва- УлаанбаатарБээжинг холбосон Транс Сибирийн олон улсын транзит төмөр зам, авто замын босоо тэнхлэгийн засмал зам дамжин өнгөрдөг. Сүмбэр сум нь замын сүлжээ сайн хөгжсөн бүс нутаг юм. Монгол улсын хойд хилээс өмнөд хил хүртэл татагдсан өндөр хурдны шилэн кабелд холбогдсон. Интернет, утсан ба үүрэн телефоны

үйлчилгээ бүрэн нэвтэрсэн, аймгийн төв болон сумдад орчин үеийн техник технологиор бүрэн тоноглогдсон Мобиком, Скайтал, Жи-Мобайл, Юнител компаниудын салбарууд үүрэн телефон, интернетийн үйлчилгээ явуулж байна.

Тус “Хос хөлөг” ХХК нь Говь-Сүмбэр аймгийн Сүмбэр сумын нутагт орших “Төмөр замын ачиж буулгах терминал” төслийг хэрэгжүүлэхдээ, байгаль орчны экологийн горимыг алдагдуулахгүй байх, ногоон байгууламжийн ажлыг зохих түвшинд чанартай гүйцэтгэж, төслийн сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээний зөвлөмж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх, мөн төслийн үйл ажиллагаандаа Монгол улсын холбогдох хууль, эрх зүйн баримт бичгүүдийг мөрдлөг болгон ажилласан гэж үзэж байна.

## ХОЁР. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлж болзошгүй нөлөөллийн эх үүсвэр болон нөлөөлөлд өртөгдөх байгаль орчин, нийгэм эдийн засгийн бүрэлдэхүүн хэсгийг “Магадлан жагсаах арга”-аар тодорхойлбол төслийн үйл ажиллагаанаас байгаль, нийгэм-эдийн засгийн бүрдэл хэсэгт хамгийн их нөлөөлөл үзүүлэх бүрдэл хэсэг нь агаарын чанар, хөрсөн бүрхэвч байна. Хамгийн их нөлөөлөл үзүүлж буй үйл ажиллагаа нь хуурай түүхий эдийг хадгалах, ачих, буулгах бөгөөд хийж гүйцэтгэх үеийн тоосжилт нь агаарын чанарт сөрөг нөлөөлөл үзүүлнэ.

Гэхдээ энэхүү төмөр замын ачиж буулгах терминал нь төсөл хэрэгжүүлэгчийн оруулж ирж буй ачаа барааг зөөвөрлөхөд шууд бөгөөд урт хугацааны эерэг нөлөөтэй. Тухайлбал авто машинаар тээвэрлэснээс замын хөдөлгөөний эрчимд үзүүлэх сөрөг нөлөөлөл арилж байна.

Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх шууд нөлөөлөл 16, шууд бус нөлөөлөл 4 байна. Нийт нөлөөллийн 7 - бага хүчтэй, 9 - дунд эрчимтэй, 4 - хүчтэй нөлөөлөлд хамрагдаж байгаа боловч нөлөөллийн эерэг, сөргөөр авч үзвэл бага эрчимтэй нөлөөллийн 1 – эерэг, 6 – сөрөг; дунд эрчимтэй нөлөөллийн 3 – эерэг, 6 – сөрөг бөгөөд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл нь шууд, дундаас урт хугацааны, дунд зэргийн эрчимтэй нөлөөлөл байгааг тогтоосон.



## ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь төсөл хэрэгжүүлэгч “Хос хөлөг” ХХК-ийн “Төмөр замын ачиж буулгах терминал” төслийн албан ёсны баримт бичиг бөгөөд байгалийн баялгийг зүй зохистой ашиглах болон байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө юм. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулахад чиглэсэн арга хэмжээ, зарцуулсан зардал зэргийг нэгтгэн тусгасан.

### 3.1. БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТ:

Байгаль орчны аудит хийлгэсэн болно.

“ХОС ХӨЛӨГ” ХХК-ИЙН “ТӨМӨР ЗАМЫН АЧИЖ БУУЛГАХ ТЕРМИНАЛ”-ИЙН ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ТАЙЛАН

**БҮЛЭГ 3. АУДИТЫН ҮР ДҮН**

Аудитын хүрээнд байгаль орчны холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартаас гадна төслийн БОНБНҮ, БОХТ, ОХШХ-ийн хэрэгжилтийг авч үзлээ.

Аудитын шалгуур үзүүлэлтийн биелэлтийг дараах 3 хэлбэрээр үнэлэв. Үнэлэмжүүдийн тайлбарыг доор үзүүлэв.

Хүснэгт 3.Үнэлэмжүүдийн тайлбар

| | | |
|---|---|---|
| 1 | Нийцэл | Хууль эрхзүйн шаардлагад нийцэж байгаа бөгөөд БОННҮ, БОМТ-ний биелэлт хангалттай тохиолдол |
| 2 | Бүрэн бус нийцэл | Хууль эрхзүйн шаардлага болон БОННҮ, БОМТ-нд тусгагдсан ажлын гүйцэтгэл дутуу тохиолдол |
| 3 | Үл нийцэл | Хууль эрхзүйн шаардлагыг хангаагүй мөн БОННҮ, БОМТ-д тусгагдсан ажлуудыг гүйцэтгээгүй тохиолдол |

Аудитын ажлын явцад нийт 98шалгуур үзүүлэлтээр үнэлсний 81 хувь нь нийцэл, 7 хувь нь үл нийцэл, 12 хувь нь бүрэн бус нийцэл гэсэн үр дүн гарсан байна.

Хүснэгт 4. Шалгуур үзүүлэлтийн үнэлэмжийн нэгтгэл

| № | БО-ы бүрэлдэхүүн хэсэг | Нийцэл | Бүрэн бус нийцэл | Үл нийцэл | Нийт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Байгаль орчны удирдлагын менежмент | 7 | 2 | 1 | 10 |
| 2 | Ус ашиглалтын менежмент | 8 | 1 | 1 | 10 |
| 3 | Газар ашиглалт, хөрсөн бүрхэвчийн менежмент | 15 | 5 | 0 | 20 |
| 4 | Биологийн олон янз байдал ба нөхөн сэргээлтийн менежмент | 6 | 0 | 1 | 7 |
| 5 | Агаар орчны менежмент | 10 | 2 | 0 | 12 |
| 6 | Хог хаягдлын менежмент | 20 | 2 | 2 | 24 |
| 7 | ХАБЭА менежмент | 13 | 0 | 2 | 15 |
| | **Нийт** | **79** | **12** | **7** | **98** |




График 1. Шалгуур үзүүлэлтийн үнэлэмжийн нэгтгэл

**3.2. Удирдлага, зохион байгуулалт:**

| Хууль эрх зүйн хүрээнд төлөвлөж хийгдэх ажлууд | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжүүлсэн байдал |
|---|---|---|
| БОНБҮТХ 6.1. Төсөл хэрэгжүүлэгч нь Байгаль орчны төлөв байдлын үнэлгээг хийлгэж, болзошгүй нөлөөллийг судалсан байна; | Байгаль орчны төлөв байдлын судалгааны ажлын тайланг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн эсэх | Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ зөвлөгөөний “Баруун хуасай” ХХК-иар 2022 онд гүйцэтгүүлсэн. |
| БОНБҮтХ 7.2. Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг байгалийн нөөцийг ашиглах, газрын тос болон ашигт малтмал хайх, ашиглах, аж ахуйн зориулалтаар газар эзэмших, ашиглах эрх авах болон төсөл хэрэгжүүлэхээс өмнө хийнэ. ГтХ55.2. Газрын хэвлийг ашиглагч нь байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, газрыг хамгаалах, нөхөн сэргээх төсөлтэй байна. ГтХ 55.3. Газрын хэвлийг ашиглагч нь үйл ажиллагаагаа эхлэхээс өмнө байгаль орчны нөлөөллийн үнэлгээг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгүүлнэ. | Төрийн захиргааны төв байгууллагаас байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргуулж, Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, төрийн захиргааны төв байгууллагаар батлуулсан эсэх | Байгаль орчин аялал жуулчлалын яамны 2023.11.20-ны өдрийн 12/605/ албан тоот, 2023/ӨМ-09 дугаар бүхий Байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргуулсан. 2022 онд БОННҮ-ний тайланг “Баруун хуасай” ХХК-иар гүйцэтгүүлж БОАЖЯ-ны мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулсан. |
| БОНБҮтХ. 9.8. Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага төсөл хэрэгжүүлэгчийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 12 дугаар сард багтаан хүлээн авч дараа оны төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлын хэмжээг батална. | Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлуулж үйл ажиллагаандаа хээргжүүлсэн байдал | 2025 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлуулсан. |
| БОХт.Х 31.1. байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, Засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллага болон Засаг | Орон нутгийн болон улсын хяналт шалгалт, бусад | Говьсүмбэр аймгийн Байгаль орчны газрын улсын байцаагчийн албан шаардлага /2025 оны 10-р |

| | | |
|---|---|---|
| даргын шийдвэр, улсын байцаагч, байгаль хамгаалагчийн шаардлагыг биелүүлэх БОХтХ 31.9. өөрийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд учруулсан хохирлыг арилгах, холбогдох байгууллагад мэдэгдэх, байгаль орчны хяналтын улсын байцаагчийн ногдуулсан нөхөн төлбөрийг ажлын 14 хоногт багтаан төлөх; | албан шаардлагад хариу арга хэмжээ авсан байдал | сарын 1- ний дотор хариу албан тоот хүргүүлсэн. / |
| БОХтХ 31.2. эрх бүхий байгууллагаас баталсан байгаль орчны холбогдолтой стандарт, хэм хэмжээ, дүрэм, журмыг чанд сахин биелүүлж, дотоодын хяналтыг хэрэгжүүлэх | Байгууллагын удирдамжийн дагуу дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлдэг эсэх | Дотоод хяналтын журам батлуулсан.<br>2025.05.01-ний өдрийн дотоод хяналт шалгалтын журам, 2025.05.05-ны өдрийн дотоод хяналт шалгалтын удирдамж, 2025.07.02-ны өдрийн дотоод хяналт шалгалтын биелэлтийн тайлан |
| ГХТХ 37.2.Газрын хэвлийг ашиглаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад аюулгүй ажиллагааны дүрэм, хэм хэмжээний биелэлтийг хангах үүргийг тэдгээрийн эрх баригчид хүлээх бөгөөд тухайн аж ахуйн нэгж, байгууллагын салбар, нэгж бүрт уг дүрэм, хэм хэмжээний биелэлтэд хяналт тавих ажлыг тодорхой ажилтанд тухайлан хариуцуулсан байвал зохино. | Дотоод хяналт шалгалт хийдэг эсэх | Дотоод хяналт шалгалтын удирдамж, журамтай. Түүнийхээ дагуу 2025 онд дотоод хяналт шалгалтын журмын биелэлтийн тайлан хийсэн. |
| БОХтХ 31.3. үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх явцад байгаль орчинд гаргаж байгаа хорт бодис, физикийн хортой нөлөөлөл, хог хаягдлын хэмжээг бүртгэж, тэдгээрийг багасгах, цэвэрлэх талаар авсан арга хэмжээ, хянах төхөөрөмжийн ажиллагааны тухай тайлан мэдээг хугацаанд нь гаргаж холбогдох байгууллагад өгөх | Хог хаягдлын бүртгэл хөтөлж, хог хаягдлын тайлан мэдээ холбогдох байгууллагад өгдөг эсэх | Хог хаягдлын ачилтын бүртгэлтэй, хог хаягдлын цэвэрлэгээ тогтмол хийдэг болов ч хог хаягдлын хэмжээг бүртгэсэн бүртгэл байхгүй байсныг бүртгэлжүүлсэн. |

| | | |
|---|---|---|
| БОХтХ 31.4. байгаль орчинд сөрөг нөлөөлөл бүхий үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагааныхаа сөрөг нөлөөллийг бууруулах, зогсоох болон байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг жил бүр төсөвтөө тусган хэрэгжүүлэх; | БОНБҮтХ 9.6. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байна. | Байгаль орчны менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг төсөвт суулгаж хэрэгжүүлдэг эсэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулж батлуулсан. |
| БОНБҮтХ 9.7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгана. | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлтийн хүрээнд агаар, ус, хөрсний чанарын хэмжилт дээжлэлт хийлгэж лабораторийн шинжилгээний үр дүн гаргуулж үнэлэлт дүгнэлт өгдөг эсэх | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлтийн хүрээнд ус, хөрс, агаарын хяналт шинжилгээг 2025 оны 6- р сард хийлгэсэн байна. 2025 оны ОХШХ-т тусгагдсаны дагуу хийлгэсэн. |



Төслийн барилга байгууламж, дэд бүтэц. “Хос хөлөг” ХХК нь үйл ажиллагааны туршид байгаль орчны сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, аюултай материал, ус, эрчим хүч болон бусад байгалийн нөөцийн хэрэглээг хэмнэх, үүсэх хог хаягдлын хэмжээг багасгах, хаягдлыг дахин боловсруулах, дахин ашиглах боломжийг нэмэгдүүлж, нийт талбайн хэмжээнээс одоогоор 1,37 га газрыг хатуу хучилттай болгосон














БАТЛАВ.
Хос хөлөг ХХК-ийн захирал
Д.Мандалмаа

2025 оны 05 сарын 01-ний өдөр

ХОС ХӨЛӨГ ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮСИЙН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЖУРАМ

**Нэг. Ерөнхий зүйл**

1.1 Энэхүү журмын зорилго нь Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1-р багт байрлах Хос хөлөг гаалийн хяналтын бүсийн (цаашид ГХБ гэх) хэмжээнд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
1.2 Хос хөлөг ГХБ-ийн бүтцийн нэгж, ажилтан нь захирлын тушаалаар батлагдсан энэхүү журмыг чанд мөрдөнө.
1.3 Журам нь "Төрийн хяналт шалгалтын тухай" хууль, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуйн нэгж байгууллагын дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ыг үндэслэл болгон хэрэгжинэ.

**Хоёр. Дотоод хяналт шалгалтын зорилго, зарчим, хамрах хүрээ**

2.1 Дотоод хяналт шалгалтын зорилго нь хууль, журам, стандартын хэрэгжилтэд хяналт тавих, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, аюулгүй ажиллагааг хангах, ажилчдын болон гуравдагч этгээдийн эрүүл мэнд, амь нас, хүрээлэн буй орчны аюулгүй байдлыг хамгаалахад чиглэнэ.
2.2 Дотоод хяналт шалгалт нь:
Хуулийг дээдлэх;
Хараат бус байх;
Ил тод байх;
Шударга, бодитой байх зарчимд тулгуурлана.
2.3 Энэхүү журмаар:
Байгаль орчны хамгаалалт, хөдөлмөрийн аюулгүй байдал;
Ачилт, буулгалтын технологийн үйл ажиллагаа;
Гаалийн хяналттай холбоотой эрх зүйн хэрэгжилт;
Галын болон хөдөлмөрийн аюулгүй байдлын шаардлага;
Ажилтнуудын сахилга, дэг журам зэрэг бүхий л үйл ажиллагаанд хяналт тавина.

**Гурав. Хяналт шалгалтын чиглэл**

3.1 Монгол Улсын хууль, стандарт, дүрэм журмын хэрэгжилт.
3.2 Байгууллагын [illegible] салбарын хууль, журам, стандартад нийцэж буй эсэх.
3.3 Ачилт буулгалтын технологийн горимын мөрдөлт



"САЙН САЙХАН КОНСАЛТИНГ СЕРВИС" ХХК-НЫ АЖИЛТНУУДАД АЖЛЫН ХУВЦАС ОЛГОСОН ЖАГСААЛТ

| № | Албан тушаалын нэр | Овог нэр | Зуны улиралд өмсөх хувцас | | | | | Өвлийн хувцас | Гарын үсэг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Ажлын тусгай хувцас | Нэг удаагийн ажлын хувцас | Хамгаалалтын малгай | Ажлын гутал | Хамгаалалтын нүдний шил | Дулаалгатай хувцас, гутал | |
| 1 | Талбайн эрхлэгч | Б.Нарантуяа | 2023он | – | 2023он | 2024он | – | 2022он | Б.Нарантуяа |
| 2 | ХАБЭА-н ажилтан | Э.Доржзэрэм | 2024он | – | 2024он | 2024он | 2024он | 2025он | [illegible] |
| 3 | Пүүлэгч | Б.Номин-Эрдэнэ | 2025он | – | 2025он | 2025он | – | | Номин-Эрдэнэ |
| 4 | Пүүлэгч | С.Цогжавхлан | 2025он | – | 2025он | 2025он | – | | Цогжавхлан |
| 5 | Ковшийн оператор | Б.Доржзэрэм | 2023он | Тухай бүр | 2024он | 2024он | 2024он | 2024он | Доржзэрэм |
| 6 | Ковшийн оператор | Н.Сүх | 2024он | Тухай бүр | 2024он | 2024он | 2024он | 2024он | Сүхээ |
| 7 | Бичиг хэргийн ажилтан | Б.Нарангэрэл | 2025он | | | 2025он | | | Нарангэрэл |
| 8 | Тогооч | Ж.Чулуунцэцэг | 2024он | – | – | – | – | 2024он | Чулуунцэцэг |

Боловсруулсан: ХАБЭА-н ажилтан Э.Доржзэрэм





**Орчны тохижилт, хашаа, Тоосжилтийг бууруулах хашаа барьж байна.**








Зураг. Байгууллагын хаалгыг гэрэлтүүлэг сайтай, Төмөр хийцлэлтэй, өнгө үзэмжтэй, Монгол бичигтэй болгосон.





Зураг. Авто пүү, хяналтын камер













### 3.3. Усан орчны менежмент

| Хууль эрх зүйн хүрээнд төлөвлөж хийгдэх ажлууд | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжүүлсэн байдал |
|---|---|---|
| УБТТХ-9 дүгээр зүйл.Төлбөрийг төлөх, тайлагнах, УТХ-25 дугаар зүйл.Ус бохирдуулсны болон хомсдуулсны төлбөр, нөхөн төлбөр тогтоох | 9.1.Төлбөр төлөгч нь тухайн улиралд байгаль орчинд шууд хаясан болон ариутгах татуургын байгууламжид нийлүүлсэн хаягдал усан дахь бохирдуулах бодист ногдох төлбөрийг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор харьяалах татварын албанд төлнө. 25.1.Ус бохирдуулагч нь хаягдал усныхаа тоо хэмжээ, найрлагад хяналт тавих, хаягдал усны стандартын шаардлагад нийцүүлэн бохир усыг цэвэрлэж зайлуулах, ус бохирдуулсны төлбөр төлөх үүрэг хүлээнэ. 30.1.3.хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл авах, ашиглалтын явцад гарах бохир усыг хаягдал усны стандартын шаардлагад нийцүүлэн цэвэрлэж, төвлөрсөн ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх, эсхүл шууд зайлуулах; | “Чойр ложистик сервис” ХХК-ийн 2024, 2025 оны Хаягдал бохир ус зайлуулах зөвшөөрөлтэй. 2024, 2025 оны хаягдал усны дүгнэлттэй. Ус бохирдуулсны төлбөр төлж ажилладаг. |
| УТХ-27 дугаар зүйл.Ус хэрэглэгчид олгох зөвшөөрөл, 32 дугаар зүйл.Усны барилга байгууламж | 27.3.Аймаг, нийслэлийн байгаль орчны алба ус хэрэглэгчийн худаг, цооногийг усны мэдээллийн санд бүртгэж, худгийн паспорт олгоно. 32.10.Усны аливаа барилга байгууламж нь паспорттай байна. | Худгийн паспорттой. |
| УТХ- 28 дугаар зүйл.Ус ашиглагчид олгох зөвшөөрөл | 28.4.Хоногт 100 шоометрээс их ус ашиглах, эрчим хүч, усан тээврийн зориулалтаар ашиглуулах дүгнэлтийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 50-100 шоометр ус болон усан орчин ашиглуулах дүгнэлтийг сав газрын захиргаа, 50 шоометр хүртэлх ус ашиглуулах, хурын ус хуримтлуулж, хөв, цөөрөм байгуулах, суваг, шуудуу | “Чойр ложистик сервис” ХХК Ус ашиглах дүгнэлтийг Усны газраар гаргуулсан. |

| | | |
|---|---|---|
| | татах дүгнэлтийг аймаг, нийслэлийн байгаль орчны алба тус тус гаргана. | |
| УТХ 29 дүгээр зүйл.Ус ашиглах гэрээ байгуулах, цуцлах | 29.1.Энэ хуулийн 28.6, 28.7-д заасан зөвшөөрлийг үндэслэн хүн амын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрээс хангагдаж байгаа ус ашиглагчтай тухайн ус хангагч байгууллага, төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрээс хангагдаж байгаа ус ашиглагчтай сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн байгаль орчны алба, сум, дүүргийн Засаг дарга гэрээ байгуулна. | Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын засаг даргын Ус ашиглах зөвшөөрлийн захирамжтай, ус ашиглах гэрээ байгуулсан.<br>Говьсүмбэр айигийн Сүмбэр сумын засаг даргын 2025.01.05-ны өдрийн А/139 тоот зөвшөөрөл олгох тухай захирамж, 06 дугаар бүхий Ус ашиглах гэрээтэй |
| УТХ-30 дугаар зүйл.Ус ашиглагчийн үүрэг, ус ашиглагчид тавигдах шаардлага, | 30.1.Ус ашиглагч дараах үүргийг хүлээнэ: 30.1.1.Ус ашиглах зөвшөөрөл, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашиглахгүй байх; | Ус ашиглах дүгнэлттэй. Тоолууртай. Тоолуурын баталгаажуулах акттай. |
| БНАТТХ-6 дугаар зүйл.Ус, рашааны нөөц ашигласны төлбөр ногдох зүйл, УТХ-31 дүгээр зүйл. | 6.1.Дор дурдсан зориулалтаар ашигласан ус, рашаан тэдгээрийн орчинд төлбөр ногдуулна: 31.1.Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ус, рашааны нөөц ашигласны төлбөр төлнө. | Ус ашигласны төлбөр Ус ашигласны төлбөр төлсөн баримттай. |
| ЭАТХ-4 дүгээр зүйл. Хүрээлэн байгаа орчинд тавих эрүүл ахуйн шаардлага | зүйл. Хүрээлэн байгаа орчинд тавих эрүүл ахуйн шаардлага 4.1.Хүн амыг ундны болон ахуйн дараахь нөхцөл, шаардлагыг хангасан усаар хангана: 4.1.1.ундны болон ахуйн ус нь эрүүл ахуйн нөхцөл, шаардлагыг хангасан, аюулгүй байх; | Унд ахуйн усны чанарыг лабораторит шинжлүүлдэг. ОХШХ-ийн хүрээнд Говьсүмбэр УЦУОШГ-н Байгаль орчны шинжилгээний лабораторийн шинжилгээний үр дүн |
| **Газрын хуулийн хүрээнд хийсэн ажлууд** | | |
| ГТХ 35.3.4. 58.4, ГТБЧЖХБХЖ 3.6 Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаар тогтоосон журмын дагуу хийлгэж байх; - | Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаар эрх бүхий мэргэжлийн байгууллага хийж, дүгнэлт гаргана; Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийлгэсэн эсэх | Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаар эрх бүхий“Ашид Ананда” ХХКиар хийлгүүлж 2017, 2024 онд тайлан хийлгүүлсэн. |

| | | |
|---|---|---|
| СӨХТХ 27-р зүйл, АМТХ-402, ГТХ 31.4, 34.11 Ашигт малтмалын ашиглалтын талбайд палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулах | Ашиглалтын талбайд палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулсан эсэх | “Соёлын Өвийг хамгаалах тухай” хуулийн 27.8-д Хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, газар тариалан эрхлэх, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгохоос өмнө палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулна гэж заасан байдаг тул уг төсөлд палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэхгүй байх үндэслэл бүрдэж байна. |
| ХХЦСТХ: 7.2.1.иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тогтоосон цэгээс бусад газарт хөрсийг хог хаягдлаар бохирдуулахгүй байх; | Хог хаягдлын нэгдсэн цэгтэй, эсэх | Хог хаягдлын тогтсон цэгтэй. Тохижилт сүмбэр онөаатүг-тэй байгуулсан хог хаягдал тээвэрлэх тухай гэрээтэй ба гэрээний дагуу тогтмол ачиж зайлуулдаг. |
| ХХЦСТХ: 7.2.5.Тогтоосон авто зогсоол болон авто замын зорчих хэсгээс бусад газарт тээврийн хэрэгсэл зогсоох, зорчихыг хориглох.БОННҮ | Чиглэл, хурд заасан замын тэмдэг, тэмдэглэгээ байгаа эсэх | Чиглэл, хурд заасан замын тэмдэг, тэмдэглэгээ байршуулсан |
| ГХТХ 36.2.Зураг төсөлд үйлдвэрлэлийн хаягдал, бохир ус, хортой болон бусад бодисыг хор хөнөөлгүй болгох буюу тэдгээрийг тогтоосон хилийн дотор тусгайлан хадгалж хамгаалах, газрын гадарга, уулын малталт, усны объектод нэвтрэхээс сэргийлэх арга хэмжээг тусгана. | Төслийн талбайг хашаажуулсан эсэх | Төслийн талбайг хашаажуулсан. |

| | | |
|---|---|---|
| ГХТХ 41.8.Газар доор нефть, хий, материалыг хадгалах, хортой болон бусад бодис, үйлдвэрлэлийн хаягдлыг хамгаалан булах, бохир ус зайлуулах үед газрын хэвлий бохирдохоос сэргийлэх; | Шатах тослох материал асгарсан үед газрын хэвлий бохирдохоос сэргийлэх арга хэмжээ авдаг эсэх | Технологийн горим алдагдсанаас түлш шингэн бодис асгаралтын үр дагаврыг арилгах багаж хэрэгсэлтэй. Шатах тослох материал асгарсан үед хусаж цэвэрлэдэг |
| MNS 5850:2019, ОХШХ-жилд 1 удаа, 9 сард-9цэгт | Хөрсний химийн задлан шинжилгээ хийлгэдэг эсэх/ 9 цэгт/, хөрсний механик бүрэлдэхүүн/ 9 цэгт/, Хүнд металлын агууламж- / As, Cr, Cd, Cu, Pb, Ni, Fe, Zn/, нефть бүтээгдэхүүний бохирдол/9цэгт / | 2025 онд Цаг уур, орчны шинжилгээний газар-Байгаль орчны хэмжил зүйн төв лабораторид 4 цэгт хүнд металлын 7 үзүүлэлтэд шинжилгээ хийлгүүлсэн байна. 2025 оны хөрсний шинжилгээний хариу |

Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний биелэлт Төслийн талбай, барилгын эргэн тойрны газарт хатуу хог хаягдал хуримтлагдах, гүний усанд бохирдол үүсэхээс сэргийлэх зорилгоор Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсанаар унд, ахуйн хэрэглээний усан хангамж, унд, ахуйн хэрэглээний усанд тогтмол шинжилгээ хийлгэж байна.





Усны тухай хуулийн 28 дугаар зүйл, 29 дүгээр зүйлийн дагуу ус ашиглуулах дүгнэлт гаргуулсан. Сүмбэр сумын Засаг даргаас ус ашиглах зөвшөөрөл авч гэрээ байгуулсан.

ГОВЬСҮМБЭР АЙМАГ,
СҮМБЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 01 өдөр — Дугаар А/199 — Сүмбэр сум

Ус ашиглах зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Усны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5, 28 дугаар зүйлийн 28.6, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх заалт, Байгаль орчны газрын 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 06 тоот ус ашиглуулах дүгнэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Ганзам багийн нутагт байрлах "Чойр ложистик сервис" ХХК-ийн тоосжилт дарахад 616.0 шоометр, ногоон байгууламжийн усалгаанд 3360.0 шоометр, нийт 3976.0 шоометр усыг 1 жилийн хугацаагаар "Чойр ложистик сервис" ХХК-д ашиглахыг зөвшөөрсүгэй.

2."Чойр ложистик сервис" ХХК-ийн төмөр замын ачиж буулгах терминал үйлдвэрийн ус ашиглалтын байдалд байнгын хяналт тавин ажиллахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Б.Уранчимэг)-д үүрэг болгосугай.

3."Төсвийн тухай хууль"-ийн 23 дугаар зүйлийн 23.6.5-д заасны дагуу үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийг Говьсүмбэр аймгийн төсөвт гэрээнд заасан хугацаанд төвлөрүүлэхийг "Чойр ложистик сервис" ХХК-ийн гүйцэтгэх захирал (Вон Чин Жим Жастин)-д үүрэг болгосугай.

4.Усны тухай хуулийн 30.1 дэх заалтын дагуу ус ашиглагчийн үүрэг, тавигдах шаардлагыг хангаж ажиллах, усны ашиглах боломжит нөөцийн хэмжээнээс хэтрүүлэн хэрэглэхгүй байх болон Усны тухай хуулийн 7.5 дахь заалтын дагуу усны мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбогдсон мэдээ, тайланг 2025 оны 12 сарын 20-ны өдрийн дотор ирүүлэхийг "Чойр ложистик сервис" ХХК-ийн гүйцэтгэх захирал (Вон Чин Жим Жастин)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Э.ДАВААДОРЖ

Умард говийн гүвээт-
Халхын дундад талын

ХАЯГДАЛ УСНЫ ДҮГНЭЛТ

2025 оны 07-р сарын 07-ны өдөр — Дугаар E-2506-000299

## Нэг. Ерөнхий мэдээлэл

**1.1. Иргэн, аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар:**

| | |
|---|---|
| Оноосон нэр: | Хосхөлөг |
| Улсын бүртгэлийн дугаар: | |
| Регистрийн дугаар: | 5353017 |
| Захирал: | Ching Him Justin |
| Холбоо барих дугаар:: | 70119966 |

**1.2. Төслийн нэр, байршил:**

| | |
|---|---|
| Төслийн нэр: | "Чойр ложистик сервис" ХХК |
| Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалт: | |
| Байршил: | Говьсүмбэр, Сүмбэр, 1-р баг |
| Дэлгэрэнгүй хаяг: | Говьсүмбэр, Сүмбэр, 1-р баг, Рокмон бюлдинг 9-902 тоот |
| Харьяалагдах сав газар: | Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газар |

## Хоёр. Хаягдал усны талаарх мэдээлэл

**2.1. Хаягдал ус хаях цэгийн байршил, цэвэрлэгээний арга, түвшин**

| | |
|---|---|
| Хаягдал ус нийлүүлэх хэлбэр: | Байгальд нийлүүлэх |
| Нийлүүлж буй хаягдал усны төрөл: | |
| Нэмэлт тайлбар: | Байгаль орчин, ногоон хөгжлийн Сайдын 2013 оны А/156 дугаар тушаалаар баталсан "Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам"-ын 2.1.4, 3.6.1 дэх заалтын дагуу хаягдал усны шугам дээр тоолуур суурилуулах<br>- "Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015" стандартаас давсан бол "Усны тухай" хуулийн 25 дугаар зүйлийн 25.2, БОАЖ-ын Сайдын 2019 оны А/635 дугаар тушаалаар баталсан "Ус бохирдуулсны нөхөн төлбөрийг шатлан өсгөх хэлбэрээрногдуулах журам"-ын дагуу нөхөн төлбөр ногдуулахыг анхаарах. |

**2.2. Хаягдал усны хэмжээ**

| Хаягдал ус нийлүүлэх байгууламж | Хүчин чадал | Хаягдал усны төрөл | Хаягдал [illegible] зайлуулах цэг | Нийлүүлэлт | Цэвэрлэгээний арга | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд,
Барилга, хот байгуулалтын сайдын
2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн
А/719/189 дүгээр тушаалын хавсралт

# ХАЯГДАЛ УС ХАЯХ, ЗАЙЛУУЛАХ ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар: 26

........Умард говийн гүвээт халхын дундад талын сав газар.... -ын гаргасан
/ Дүгнэлт гаргасан байгууллага /

20... оны ... дугаар сарын ....-ны өдрийн хаягдал ус хаях, зайлуулах ......26 тоот дүгнэлтийг үндэслэн ..........Говьсүмбэр...... аймаг/нийслэл ..........Сүмбэр.... сум/дүүргийн ..........1 дүгээр баг.......... байршилтай
/ хаяг /

..........Төмөр замын ачиж буулгах терминал..........
/ үйл ажиллагааны чиглэл /

чиглэлээр хаягдал ус гаргаж байгаа ..........“ЧОЙР ЛОЖИСТИК СЕРВИС” ХХК... -д
/ хүн, хуулийн этгээдийн нэр /

..........Говьсүмбэр.... аймаг/нийслэл, ..........Сүмбэр..........сум/дүүргийн

..........3-р баг Орбитын ус цэвэрлэх байгууламж...... байршилтай хаягдал ус зайлуулах цэг буюу хүрээлэн буй орчинд болон төвлөрсөн бохир усны шугамд жилд ..........192.5........ мян.м³ хаягдал усыг “Хүрээлэн байгаа орчин, Усны чанар, хаягдал ус, ерөнхий шаардлага MNS 4943:2015”, “Хүрээлэн байгаа орчин, усны чанар, Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус, ерөнхий шаардлага MNS 6561:2015” стандартаар тогтоосон норматив шаардлагад нийцүүлэн хаях, зайлуулах зөвшөөрлийг
/ аль нь болохыг доогуур нь зурах /

нэг жилийн хугацаагаар олгож, ус бохирдуулсны төлбөрийн гэрээ болон дүгнэлтийг зөрчөөгүй тохиолдолд зөвшөөрлийг жил бүр сунгагдсанд тооцно. Хаягдал усны хэмжээ болон хаягдал ус зайлуулах цэг, төвлөрсөн бохир усны шугамын байршил өөрчлөгдсөн тохиолдолд тухай бүр шинээр зөвшөөрөл олгоно.

Зөвшөөрлийн бичиг олгосон:

| ....Сүмбэр сум Засаг дарга.... | .................... | /.....Т.БАТ-ЭРДЭНЭ |
|---|---|---|
| / Зөвшөөрөл олгосон байгууллага / | / Гарын үсэг / | / Гарын үсгийн тайлал / |

Тамга

2024 оны 08-р сарын ...-ны өдөр

СУНГАЛТ

| Сунгалт хийсэн шийдвэр | Огноо | Гарын үсэг / тамга |
|---|---|---|
| сунгалт хийв | 2025. 09.10 | |

Манай компани нь нийгмийн хариуцлагын хүрээнд $46^0 20^0 54$, $108^0 21^0 03$ дугаар бүхий цэгт ногоон байгууламжийн усалгаанд зориулан шинээр худаг гаргасан.

Байгаль орчын газрын 2025 оны 5 сарын 22-ны 115 дугаар тоотоор цооног өрөмдөх зөвшөөрөл авсан.



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАР

2025.05.22 № 115
танай 2025.05.20-ны № 17

"ЧОЙР ЛОЖИСТИК СЕРВИС" ХХК-Д

Цооног өрөмдөх зөвшөөрөл олгох тухай

Танай компаниас ирүүлсэн тус аймгийн Сүмбэр сумын 1 дүгээр баг, төмөр замын баруун талд байрлах нийтийн эзэмшлийн талбайд ногоон байгууламжийн усалгааны зориулалтаар цооног өрөмдөх, худаг гаргах зөвшөөрөл хүссэн албан хүсэлттэй танилцлаа.

Монгол Улсын Усны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх заалтыг үндэслэн цооног өрөмдөх, худаг гаргахыг дараах нөхцөлтэйгээр зөвшөөрч байна. Үүнд:

1. Усны тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу Усны мэргэжлийн байгууллагаар цооног өрөмдүүлэх
2. Өрөмдлөгийн явцад хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх, цооногоор дамжин гүний ус бохирдохоос сэргийлж хатуу, шингэн хог хаягдлыг зайлуулах
3. Цооногийг стандартын дагуу барилгажуулж, стандарт хэмжил зүйн газраар баталгаажуулсан баталгаат тоолуурыг орон нутгийн мэргэжлийн байгууллагаар суурилуулж акт үйлдэх
4. Цооног өрөмдүүлсэн байгууллагаасаа худгийн паспортыг 2 хувь бичүүлэн авч манай байгууллагаар баталгаажуулан, улсын усны мэдээллийн санд бүртгүүлэх
5. Улсын Тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6-д заасны дагуу 480,000 /дөрвөн зуун наян мянга/ төгрөгийг Сүмбэр сумын Төрийн сангийн Улсын тэмдэгтийн хураамжийн 100220500941 тоот дансанд төвлөрүүлэх
6. Цаашид цооногийг ашиглах явцдаа ашиглалтын зориулалтыг өөрчлөхгүй байхад анхаарч Усны тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан ус ашиглагчийн үүрэг, ус ашиглагчид тавигдах шаардлагыг хангаж ажиллах

Дээр дурьдсан шаардлагуудыг бүрэн биелүүлээгүй тохиолдолд уг зөвшөөрөл хүчингүйд тооцогдох бөгөөд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэхийг анхааруулья.

ДАРГА Г.ХОНГОР

4225020065




### 3.4. БОННҮ, БОМТ ОХШХ-ийн хэрэгжилт

| Хууль эрх зүйн хүрээнд төлөвлөж хийгдэх ажлууд | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжүүлсэн байдал |
|---|---|---|
| БОМТ-Нунтаг ачаа хураах задгай талбайг бетондож, нүүрс орчинд тархахгүй байхаар бетон хашилт хийх бетондох, үерийн хамгаалалт, даланг инженерийн нарийвчилсан үндэслэл тооцоотой хийж өгөх | БОМТ -Ажилчид, суурин дахь захиргаа-үйлчилгээний ажилчдын зорчих явган хүний зам, талбайг зориулалтын хайрган хучилттай болгох | БОМТ- Агуулах, ил задгай талбайн шалыг Төслийн талбайг хатуу хучилттай болгосон эсэх Нийт талбайн хэмжээнээс одоогоор 2 га газрыг хатуу хучилттай болгосон ба жил бүр нэмэгдэж бүх талбайг хатуу хучилттай болгоно. |
| БОМТ- Ногоон зурвас байгуулах | Ногоон зурвас байгуулсан эсэх | Ногоон зурвас байгуулсан. |
| БОМТ -Нунтаг ачаа тээвэрлэх тээврийн хэрэгслийг тогтоосон маршрутаар явуулах | Тээврийн хэрэгслийг тогтоосон маршрутаар явуулдаг эсэх | Тээврийн хэрэгсэл автопүүнээс зүүн тийшээ чиглэлтэй ороод баруун тийшээ гардаг. |

### 3.5. Биологийн олон янз байдал ба нөхөн сэргээлтийн менежмент

| Хууль эрх зүйн хүрээнд төлөвлөж хийгдэх ажлууд | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжүүлсэн байдал |
|---|---|---|
| БОНБНҮтХ 6.1.Төсөл хэрэгжүүлэгч нь Байгаль орчны төлөв байдлын үнэлгээг хийлгэж, болзошгүй нөлөөллийг судалсан байна. | Ургамал амьтны суурь судалгаа, тэдгээрт үзүүлэх нөлөөллийг судалж тодорхойлсон эсэх | Төсөл хэрэгжүүлэгчийн 2022 онд “Баруун хуасай” ХХК-иар БОТБҮ-ний тайланг хийлгүүлж холбогдох бүлэгт амьтан, ургамалд үзүүлэх нөлөөллийг тодорхойлсон. |
| ХХЦСТХ 7.2.4. иргэн, аж ахуйн нэгж, байгууллага эзэмшлийн болон өмчлөлийн газрын 10 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу мод тарьж, зүлэгжүүлэх, ГТХ, БОХТХ 25.1.2 ,БОННҮ | Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага эзэмшлийн болон өмчлөлийн газрын 10 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу мод тарьж, зүлэгжүүлэх | “Тэр бум мод үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд 2025 онд 60 сая төсөвт өртөгт бүхий 5071 мод. 90м2 талбайд зүлэг. 2024 онд 4 сая төгрөгийн 100 ширхэг эмийн мод тарьж өмнөх оны тарьсан мод бутаа арчлан ургуулж байна. |
| АТХ 6.1.7.Үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны явцад амьтан устахаас урьдчилан сэргийлэх Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенци. | 5 дугаар зүйл: Амьтан устахаас урьдчилан сэргийлэх талаар авсан арга хэмжээ | Төслийн талбайг хот суурин, хүний ойр орчимд амьдардаг амьтад орхоос хамгаалж хашаажуулсан. |
| УХТХ 13.2.1.ашиглаж, эзэмшиж байгаа болон өмчийн газарт нь ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамал илэрвэл өөр газарт тархахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг шуурхай авах, тухайн сум, дүүргийн Засаг даргад мэдэгдэх; | Ашиглаж, эзэмшиж байгаа газарт нь ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамал илэрсэн эсэх, илэрсэн бол өөр газарт тархахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг шуурхай авсан эсэх, тухайн сум, дүүргийн Засаг даргад мэдэгдсэн эсэх | Өнөөгийн байдлаар эзэмшлийн талбайн ойр орчимд ургамал, амьтны болон малын гоц халдварт ямар нэгэн аюулт өвчин эмгэг бүргэгдээгүй байна. |

Холбогдолтой зураг хавсаргав.

Авто машины зогсоол



Төслийн талбайд байршуулсан гэрэлтүүлэг





Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний биелэлт Ургамлан нөмрөг устаж шууд нөлөөлөлд өртөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд төслийн талбайд 5071 ширхэг мод тарих ажлыг мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар хийж гүйцэтгэсэн. Хүн болон машин механизмуудын замбараагүй хөдөлгөөнөөс болоод ургамлан нөмрөг доройтохоос сэргийлж үйл ажиллагааны нөлөөлөлд өртөөгүй газруудад зөвшөөрөлгүй автомашин, машин механизмуудын хөдөлгөөнийг хориглох төслийн талбайд явган хүний болон машин техникийн хөдөлгөөний зам, маршрутыг тогтоож, тэмдэгжүүлж, даган мөрдөж байна.















Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн заалтын дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил газрын 10%-иас доошгүй талбайд зохих журмын дагуу мод тарьж зүлэгжүүлэх шаардлага, Газрын тухай хуулийн 56.6 заалт, 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний, орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөнд ачилт буулгалтын талбайд мод бут сөөг тарих нөхөн сэргээх ажлыг MNS 4918:2000 стандартын дагуу ургамалжуулалт, ногоон байгууламж, мод тарих ажлын хүрээнд мод тарьсан.





































Хориглох тэмдэг тэмдэглэгээ байршуулсан байдал



Талбай бетондсон зураг




### 3.6. Агаар орчны менежмент-АОМ

| Хууль эрх зүйн хүрээнд төлөвлөж хийгдэх ажлууд | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжүүлсэн байдал |
|---|---|---|
| АтХ 9.1.2. Агаар хамгаалахтай холбогдсон дүрэм, журам, бохирдуулагч бодисын хаягдлын стандарт, хэм хэмжээний шаардлагыг хангах MNS 4585:2016 | Агаарын чанар стандартын шаардлага хангаж буй эсэх | 2025 оны 06 сарын 02-ны өдөр Говьсүмбэр УЦУОШТ байгаль орчны шинжилгээний лабораторoор агаарын чанарын шинжилгээ хийлгэсэн нь стандартаас даваагүй байсан. |
| АтХ 9.1.6. Агаар хамгаалах талаар мэргэжлийн байгууллагаас арга зүйн туслалцаа, зөвлөгөө авах; | БОННҮ, БОМТ хийгддэг эсэх. | Түүнд агаарт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ багтсан эсэх Төсөл хэрэгжүүлэгчийн 2024 онд хийлгэсэн БОННҮ-ний тайланд агаарт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан бууруулах арга хэмжээ тусгасан. |
| АТХ 20.6.Зориулалтын бус газарт хог хаягдал хаях, ил задгай шатаах болон хог хаягдал устгах стандартын шаардлага хангаагүй | Зориулалтын бус газарт хог хаягдал хаях, ил задгай шатаах болон хог хаягдал устгах | Хог хаягдлын цэгт ил задгай хог хаягдлыг шатаадаггүй. Дорноговь аймгийн Сүмбэр ОНӨААТҮГ-тэй байгуулсан хог хаягдал ачиж тээвэрлэх тухай гэрээтэй ба |

| | | |
|---|---|---|
| аливаа үйл ажиллагааг хориглоно. | стандартын шаардлага хангаагүй аливаа үйл ажиллагааг хориглох | гэрээний дагуу тогтмол ачиж зайлуулдаг. |
| 9.1.9.агаарын бохирдлыг бууруулах техник, технологи, шингэрүүлсэн хийн түлш, бусад эх үүсвэрийг ашиглах; | Агаарын бохирдол бууруулах технологи нэвтрүүлсэн эсэх | Төсөл хэрэгжүүлэгч нь халаалтаа шалны халаалтаар шийдсэн. Гал тогоондоо газ ашигладаг |
| БОХТХ 31.7 /бохирдлын эх үүсвэр бүхий аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, өөрийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд ялгаруулж байгаа хатуу, шингэн, хийн хаягдлыг хянах ажлыг зохион байгуулж ажиллуулах үүрэг бүхий дотоод хяналтын нэгжтэй байх. | Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд ялгаруулж байгаа хатуу, шингэн, хийн хаягдлыг хянах ажлыг зохион байгуулж ажиллуулах үүрэг бүхий дотоод хяналтын нэгжтэй эсэх | Талбайн инженер Б. Нарантуяа хариуцан ажилладаг. |
| АБТТХ 9.3 Төлбөр төлөгч нь автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэлд ногдох жилийн төлбөрийг жилд нэг удаа тухайн жилийн 6 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө харьяалах татварын албанд төлөх бөгөөд автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн техникийн үзлэгийн гэрчилгээ нь агаарын бохирдлын төлбөр төлсөн тухай тэмдэглэлтэй байна. MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин – утааны найрлага дах хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга | Агаар бохирдуулсны төлбөр төлсөн эсэх | 2868УР, 3031УР, 6868УР гэсэн дугаартай 3 авто ачигч, 6808УР Экскаватор ашигладаг ба Техникийн хяналтын үзлэгт орсон. |
| Боннү-Хүнд техник, автомашины хөдөлгөөнөөс үүсэж болох агаарын тоосжилтоос урьдчилан сэргийлэхийн тулд хэт хуурай, салхины хурд ихтэй үед үйлдвэрлэлийн талбай, замыг услах ажлыг зохион байгуулах | Тоосжилтоос хамгаалж авч байгаа арга хэмжээ байгаа эсэх | Тоосжилтоос сэргийлж усалгаа хийдэг. Одоо тоосжилт, салхинаас хамгаалах хашаа барьж байна. Суурийг цутгасан. |

| | | |
|---|---|---|
| Тоосжилтоос сэргийлж усалгаа хийдэг. Одоо Салхинаас хамгаалах хашаа барьж байна. | | |

Агаарын чанарын шинжилгээ хийсэн

ГОВЬСҮМБЭР УЦУОШТ
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ
ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

2025 оны 06 сарын 02 өдөр Дугаар 06 Чойр

Дугаар, он /№ :05/06/2025
Сорьц ирүүлсэн байгууллагын нэр, хаяг, утас :"Хос хөлөг ХХК"
Сорьц авсан хүний нэр, албан тушаал : Код-2
Сорьц авсан аймаг, сум, газрын нэр : Говьсүмбэр аймаг, сүмбэр сум
Сорьц авсан төрөл, хэмжээ, тоо : Агаар $SO_2$-$NO_2$, 20 минут, 1 цэг
Сорьц авсан огноо : 2025.05.06
Лабораторид ирсэн огноо : 2025.05.06
Шинжилгээ хийсэн огноо : 2025.05.06
Хуудасны тоо : 1
Хэвлэсэн огноо : 2025.06.02

| № | Сорьц авсан цэг | Сорьц авсан өдөр | Сорьц авсан цаг | Хүхэрлэг хий мг/м$^3$ | Азотын давхар исэл мг/м$^3$ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Ажлын талбай | V/06 | 14:00 | 0.012 | 0.025 |
| | **Агаарын чанарын стандарт MNS 4585:2016** | | | **0.450** | **0.200** |

Шинжилгээ боловсруулсан: БОШЛ-ийн инженер /Т. Оюунгэрэл/
Хянасан: Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ш. Мөнгөнцэцэг/

Хөрсөн бүрхэвчийн хяналт шинжилгээ

Хөрсний мониторинг хийх нийт 2 цэгээс өнгөн хөрсний буюу 0-20 см гүнээс дээжлэлт хийсэн. Хөрсний бохирдолын дээжийг холимог дээж байдлаар авсан. Дээжийг авахдаа "Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд MNS 3298 : 1990" стандартыг баримталсан.

Лабораторийн задлан шинжилгээ Хөрсний дээжнүүдэд агро-хими, физик шинж, хүнд зэрэг үзүүлэлтүүдийг лабораторийн задлан шинжилгээний аргаар тодорхойлсон. Хөрсний агрохимийн шинж чанарын үзүүлэлтүүдийг Байгаль орчин хэмжилзүйн төв лабораторийн Хөрсний итгэмжлэгдсэн лабораторид тодорхойлуулсан болно.

Хөрсний мониторинг цэгийн байршлын зураглал хийхдээ Газарзүйн Мэдээллийн Системийн ArcGIS 10.4.1 программ дээр хийж гүйцэтгэсэн. Хэвлэлийн эхийг A4 хуудсан дээр 1:14000 масштабтай бэлдсэн.

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН ХЭМЖИЛ ЗҮЙН ТӨВ ЛАБОРАТОРИ
17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж, Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Улаанбаатар хот
Утас: 11-341818 И-мэйл: bohztl@gmail.com

СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№ : 2025/239-241
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг,утас : "Хос хөлөг" ХХК
Сорьц авсан хүний нэр,албан тушаал : Т.Оюунгэрэл БОШЛ-ийн шинжээч
Сорьцын тоо,төрөл : 4 хөрсний сорьц
Сорьц авсан огноо : 2025.05.23
Сорьцын тодорхойлолт : Говьсүмбэр аймаг Сүмбэр сум
Шинжилгээний аргын стандарт : САЗ А01:2022
Шинжилсэн огноо : 2025.06.05
Хуудасны тоо : 1/1
Үр дүн

| № | Сорьц авсан цэгийн нэр | Кадьми (Cd) | Хар тугалга (Pb) | Мөнгөн ус (Hg) | Хром (Cr) | Цайр (Zn) | Зэс (Cu) | Стронци (Sr) |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | мг/кг | | | | | | |
| 1 | Буулгалтын талбай | <0.05 | 17 | <0.005 | 2.8 | 36 | 26 | 327 |
| 2 | Жоншны талбай | <0.05 | 17 | <0.005 | <0.5 | 235 | 27 | 330 |
| 3 | Ачилтын талбай | <0.05 | 15 | <0.005 | <0.5 | <0.5 | 28 | 364 |
| 4 | Эрүүл цэг | 2.1 | 21 | <0.005 | <0.5 | 115 | 28 | 430 |
| | **MNS 5850:2019/ ЗДХ/** | **3** | **100** | **2** | **150** | **300** | **100** | **800** |

Шинжилгээ гүйцэтгэсэн: Шинжээч Д.Баярхулан
Хянаж баталгаажуулсан: Ахлах шинжээч Б.Алтантуяа
Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

Хөрсний мониторингийн цэгийн байршил




















Усны шинжилгээний лаборатори нь биоген элементүүд болох аммони (NH4), нитрит (NO2), нитрат (NO3), исэлдэх чанар (ПИЧ), гол ионууд болох сульфат (SO4), төмөр (Fe), ерөнхий хатуулаг, кальци (Ca2+), магни (Mg2+) зэргийн агууламжийг тодорхойлдог ба усны шинжилгээ хийсэн.



### 3.7. Хог хаягдлын менежмент

| Хууль эрх зүйн хүрээнд төлөвлөж хийгдэх ажлууд | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжүүлсэн байдал |
|---|---|---|
| 10 дугаар зүйл. Хог хаягдлын талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг | 10.2.1.энэ хуулийн 9.1.3-т заасан журмын дагуу энгийн хог хаягдлаа ангилан ялгах; | Энгийн хог хаягдлыг ангилан ялгах савыг ажилчдын байр, пүүний байр, гал тогоонд байршуулсан. |
| | 10.2.2.энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан хогийн савтай байх; | Ахуйн гаралтай хог хаягдлыг хадгалах хогийн сав нь хуулийн шаардлагыг хангасан. |
| | 10.2.3.аж ахуйн нэгж, байгууллага нь хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулах; | “Тохижилт сүмбэр ОНӨААТҮГ”-тэй “Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, тэдгээрт хяналт тавих тухай гэрээ байгуулсан |
| | 10.2.4.хог хаягдлаа зориулалтын хогийн сав болон цэгт хаях эсхүл хог хаягдал цуглуулж тээвэрлэх эрх бүхий байгууллагад шилжүүлэх; | “Тохижилт сүмбэр ОНӨААТҮГ”-тэй “Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, тэдгээрт хяналт тавих тухай гэрээ байгуулсан. |
| | 10.2.6.нийтийг хамарсан цэвэрлэгээ, иргэдийн бүлгээс зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцох; | Байгууллагын ажилтнуудыг хамарсан нийтийг хамарсан их цэвэрлэгээг тодорхой хугацаанд зохион байгуулдаг |
| | 10.2.7.хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тогтоосон хугацаанд төлөх; | Хог хаягдлын гэрээний дагуу хог хаягдлын үйлчилгээний хураамж сар бүр 70,000 төгрөгийг Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ-т шилжүүлдэг. |
| | 10.2.8.хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх; | Хог хаягдлынг ангилан ялгах хэьшил хэрэгжүүлэхээр ажилалж байна. 2025 онд 2 тн хог ангилан ялгаж дахиварын цэгт өгсөн. |
| | 10.2.10.энэ хуулийн 9.4.12-т заасан нийтийн эдэлбэр газрын хог хаягдал, цас, мөсийг цэвэрлэх; | Төсөл хэрэгжих орчны зам дагууд хог хаягдлыг цэвэрлэх, цас мөс үүссэн |

| | | |
|---|---|---|
| | | тохиолдолд цэвэрлэн ажилладаг. Хоггүй Сүмбэр фейсбүүк группт оруулсан мэдээлэл |
| | 10.2.16.аж ахуйн нэгж, байгууллага нь байгууллагын ажилтнуудад хог хаягдлын менежментийн талаар сургалт зохион байгуулж, зохих мэдлэгийг эзэмшүүлэх, дадал зуршлыг хэвшүүлэх; | Байгууллагын 5 ажилтан хог хаягдлын сургалтанд хамрагдсан. |
| | 10.2.17.үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг ангилан ялгах, хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, шатаах, устгах эрх бүхий байгууллагад шилжүүлэх, эдгээр үйл ажиллагаатай холбоотой гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, байгууллагын дотоод болон гадна орчны цэвэрлэгээг хариуцах үүрэг бүхий нэгж, эсхүл ажилтантай байх; | Байгууллагын ажилчид хариуцан дотор болон гадна орчны цэвэрлэгээг тогтмол хийдэг. |
| 15.1. Нийтийн эдэлбэр газар байршуулах хогийн сав дараахь шаардлагыг хангасан байна | 15.1.1.хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн; 15.1.2.галд тэсвэртэй материалаар хийгдсэн; 15.1.3.хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн. | Хогийн цэгийн хогийн савыг хуулийн шаардлагад нийцүүлсэн. |
| 16 дугаар зүйл. Энгийн хог хаягдал сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах, булшлах | 16.6.Сэргээн ашигласан, дахин боловсруулсан, устгасан, булшилсан хог хаягдлын бүртгэл хөтөлж мэдээллийн сан бүрдүүлнэ. | Энгийн хог хаягдлын бүртгэл хөтөлдөг. |
| 21 дүгээр зүйл. Аюултай хог хаягдал үүсгэгч болон тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгчийг бүртгэх | 21.1.Аюултай хог хаягдал үүсгэгч болон аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч нь энэ хуулийн 8.1.9.а-д заасны дагуу бүртгүүлж, бүртгэлийн дугаар авсан байна. | Аюултай хог хаягдал үүсгэгчийн Y002107 бүртгэлийн дугаартай. |
| 22 дугаар зүйл. Аюултай | 22.1.Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж, зориулалтын саванд савлаж хадгална | Аюултай хог хаягдлын зориулалтын саванд хадгалж |

| | | |
|---|---|---|
| хог хаягдлыг савлах | 22.2.Аюултай хог хаягдал савлаж хадгалах сав нэг бүр нь “Аюултай хог хаягдал” гэсэн бичиглэлтэй, стандартаар тогтоосон тэмдэг, тэмдэглэгээтэй байх ба ил харагдахуйц газар тухайн хаягдлын нэр, хуримтлуулж эхэлсэн хугацааг тэмдэглэсэн байна. | байна. Гадна талд тэмдэг тэмдэглэгээтэй, аюултай хог хаягдалын зориулалтын талбай бий болгосон. |

**Хог хаягдлыг бууруулах, байгальд орчинд сөрөг нөлөөлөлгүй байх чиглэлээр хийсэн ажлууд:**



БАТЛАВ.
Хос хөлөг ХХК-ийн захирал
Д.Мандалмаа

2025 оны 05 сарын 02-ны өдөр

**ХОС ХӨЛӨГ ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮС**
**ХОГ ХАЯГДЛЫН ЖУРАМ**

**Нэг. Ерөнхий зүйл**

1.1 Энэхүү журам нь Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1-р багт байрлах “Хос хөлөг” гаалийн хяналтын бүсийн (цаашид ГХБ гэх) ачилт буулгалтын талбай болон бусад бүсийн хэмжээнд хог хаягдлыг ангилан ялгах, тээвэрлэх, хадгалах, зайлуулах үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2 Журам нь “Хог хаягдлын тухай” хууль, “Байгаль орчныг хамгаалах тухай” хууль, Монгол Улсын стандарт болон бусад холбогдох эрх зүйн баримт бичигт нийцнэ.

1.3 Хог хаягдлын менежментийн зорилго нь:

- Байгаль орчинд сөрөг нөлөөллийг бууруулах;
- Хог хаягдлыг зөв зохистой цуглуулах, ангилах, тээвэрлэх, устгах;
- Дахин ашиглах боломжтой хаягдлыг ангилан ялгаж эдийн засгийн эргэлтэд оруулах;
- Ажилчид, хэрэглэгчдийн аюулгүй, цэвэр орчныг бүрдүүлэхэд чиглэнэ.

**Хоёр. Хог хаягдлын ангилал**

2.1 ГХБ-д үүсэх хог хаягдлыг дараах байдлаар ангилна:

- **Энгийн хатуу хог хаягдал:** ахуйн хог, сав баглаа боодол, хүнсний үлдэгдэл.
- **Аюултай хог хаягдал:** тос, шатахуун, тосон материал, батарей, химийн бодисын сав, гэрэлтүүлэгч (ламп, аккумлятор гэх мэт).
- **Дахин боловсруулах боломжтой хог хаягдал:** төмөр, зэс, хуванцар, цаас, шил.

**Гурав. Хог хаягдлыг цуглуулах, хадгалах журам**

3.1 Ахуйн хог хаягдлыг зориулалтын хогийн саванд ангилан хийнэ.



Батлав. Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ
Дарга-г ............
Ц.Энхжаргал

Батлав
Хос хөлөг ХХК

Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, тэдгээрт хяналт тавих тухай гэрээ

20 25 оны 01-р сарын 02 -ны өдөр Говьсүмбэр аймаг

Нэг. Нийтлэг үндэслэл

Хог хаягдлын тухай хууль, ГовьСүмбэр аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн тогтоол 2023оны 07дугаар сарын 05 өдөр Дугаар 04 тогтоол, Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагын хог хаягдлыг тээвэрлэх, хог хаягдал гаргасны болон тээвэрлэлтийн төлбөрийг орон нутгийн төсөвт хуримтлуулах үйл ажиллагаа, мөн хог хаягдалтай холбогдож үүссэн харилцааг энэхүү гэрээгээр зохицуулна.

Хоёр. Тээвэрлэгч байгууллагын эрх, үүрэг

1.Гэрээний дагуу хог хаягдлыг түргэн шуурхай ачиж тээвэрлэнэ.
2.Хог хаягдлын хуулийн дагуу үйлчилгээний хураамжийг нэхэмжлэх, төсөвт төвлөрүүлэх,
3.Үйлчлүүлэгч Байгууллагын саналыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлнэ
4.Гэрээ байгуулах, хяналт шаардлага тавих, төлбөр хураах ажлыг “Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ-ын ОРЛОГО БҮРТГЭЛИЙН ТООЦООНЫ НЯГТЛАН БОДОГЧ,хог хаягдал хариуцсан байцаагчтай хариуцна.








ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАР

Ногоон хөгжлийн төв, Залуучуудын өргөн чөлөө II-208,
2 дугаар баг, Сүмбэр сум, Говьсүмбэр аймаг, 42017
Утас/Факс: (976) 7054 3063,
Цахим шуудан: baigaliorchin.gsa@baigal.gs.gov.mn,
Цахим хуудас: www.baigal.gs.gov.mn

2025.07.30 № 187

танай ____________-ны №____________-т

ХОС ХӨЛӨГ XXK-Д

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас гарах аюултай хог хаягдлыг Хог хаягдлын улсын мэдээллийн сан /Аюултай хог хаягдал үүсгэгч болон тээвэрлэх, цуглуулах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгжийг бүртгэх бүртгэлийн хуудас/-д бүртгэж, дугаар олгов.

Бүртгэлийн дугаар: Y-002107

ДАРГА Г. ХОНГОР

**Аюултай хог хаягдал** – аюултай хог хаягдлыг цэгтэй болж, тогтмол хяналт тавьж, гэрээт газарт аюултай хог хаягдлыг шилжүүлэн ажиллаж байна. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасны дагуу аюултай хог хаягдал түр хадгалах цэг байгуулж бэлдсэн болно. 2025 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний аюултай хог хаягдлын менежментэд тусгаснаар аюултай хог хаягдлын цэг байгуулж, машин техникийн төмөр сэлбэг хэрэгсэл болон дугуйн хаягдлыг тусгай талбайд хуримтлуулан эрх бүхий дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэхээр төлөвлөсөн. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасны дагуу автомашины зогсоол, нүүрс ачих буулгах талбайн орчинд машины сэлбэг хэрэгсэл, дугуйн хаягдлаар хөрс бохирдохоос урьдчилан сэргийлж сэлбэг хэрэгсэл, дугуйн хаягдлыг тусгаарласан хашлага бүхий тусгай талбайд хуримтлуулахаар төлөвлөн суурь бэлдэж, аюултай хог хаягдал түр хадгалах цэг байгуулсан. Аюултай хог хаягдлын цэгийн хүлээлгэн өгөх хуудас хөтөлсөн. Аюултай хог хаягдал үүсгэгчээр бүртгүүлж, Y дугаар авсан.













ХОС ХӨЛӨГ ТАЛБАЙ

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ
ХУРИМТЛУУЛСАН ТЭМДЭГЛЭЛ





| № | Огноо | Төрөл | Хэмжээ л | Компанийн оператор Нэр | Хяналт хийсэн ажилтан Гарын үсэг |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2025.1.02 | Масло | 40л | [illegible] | |
| 2 | 2025.01.02 | [illegible] | 40л | [illegible] | |
| 3 | 2025.3.15 | Масло | 36л | [illegible] | |
| 4 | 2025.3.15 | Шүүр | 4ш | [illegible] | |
| 5 | 2025.6.7 | Масло | 40л | [illegible] | |
| 6 | 2025.9.9. | Масло | 40л | [illegible] | |







**Барилгын болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг 2 удаа цэвэрлэсэн.**










SEM






SEM

### 3.8. ХАБЭА менежмент

| Хууль эрх зүйн хүрээнд төлөвлөж хийгдэх ажлууд | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжүүлсэн байдал |
|---|---|---|
| ЭАТХ-13 дугаар зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг ХАБЭАТХ-27 дугаар зүйл.Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтэц, зохион байгуулалт | 13.1.Аж ахуйн нэгж, байгууллага нь дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ: 27.2.Ажил олгогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний онцлог, ажлын байрны эрсдэлийн түвшин, ажилтны тоог харгалзан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтэц болон ажилтан, зөвлөл ажиллуулна | ХАБЭА ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна. |
| ГАБТХ-17 дугаар зүйл. Галын аюулгүй байдлыг хангах талаар аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг | 17.2.Галын аюулгүй байдлыг хангах талаар аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага дараах үүрэг хүлээнэ: 17.2.1.холбогдох хууль тогтоомж, галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичгийн шаардлагыг биелүүлэх, галын аюулгүй байдлыг хариуцсан албан тушаалтныг томилох; 17.2.2.тухайн аж ахуйн нэгж, байгууллагын галын аюулгүй байдлыг хариуцан хангах, шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгах; 17.2.11.галын аюулгүй байдлыг хангах талаар байгууллагын хэмжээнд галын сайн дурын бүлгэм ажиллуулах. | Галын аюулгүй байдлын дүгнэлтийг Говьсүмбэр аймгийн Онцгой байдлын газраар гаргуулсан<br><br>Гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж, анхан шатны багаж хэрэгсэл, бодис материал зэргийг шаардлагатай газруудад суурилуулсан.<br><br>Гал унтраах шуурхай төлөвлөгөөтэй.<br><br>Гамшигаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулж батлуулсан |
| ЭАТХ-14 дүгээр зүйл. Эрүүл мэндийн үзлэг 14.1.Ажил олгогч нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон журмын дагуу үйлдвэрлэл, ажил, үйлчилгээтэй холбоотой, зайлшгүй шаардлагатай эрүүл мэндийн урьдчилсан ба | 14.2.Энэ хуулийн 14.1-д заасны дагуу эрүүл мэндийн үзлэг хийлгэхэд шаардагдах зардлыг ажил олгогч хариуцна. 14.3.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд гүйцэтгэж буй тухайн ажил, хөдөлмөрт шаардлагатай бол эмнэлгийн үзлэгт орсон байна. | Нийт ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан |

| | | |
|---|---|---|
| хугацаат үзлэгт ажилтныг хамруулна. | | |
| ХАБЭАТХ-15 дугаар зүйл. Ажилтныг ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах | 15.1.Ажил олгогч нь ажилтныг түүний ажлын нөхцөл, ажил үүргийн онцлогт тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр үнэ төлбөргүй хангах үүрэгтэй. | Ажлын хувцас хамгаалах хэрэгсэл, хамгаалах хэрэгслийг ашиглан ажиллаж байна. |
| ХАБЭАТХ-17 дугаар зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон мэргэжлийн сургалт | 17.1.Ажил, хөдөлмөр эрхэлж байгаа иргэн, ажилтан болон ажил олгогч нь хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдаж мэдлэг, дадлагатай болсон байна. | Гаалийн хяналтын талбайн ажилчдыг сургалтанд хамруулдаг. |
| ГХТХ-2-р бүлгийн 7-р зүйл. Гамшгийн эрсдлийг үнэлэх | 2.7.1. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд нь өмчийн хэлбэрийг үл харгалзан гамшгийн эрсдэлийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийнэ. “Очир сэргээн босголт” ХХК гүйцэтгэсэн. | “Хос хөлөг” ХХК-ийн “Ачилт буулгалтын талбайн гамшгийн эрсдлийн үнэлгээ” |



“Хос хөлөг ХХК” ХХК нь Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулж үзүүлэх сургууль, дадлага хийсэн.












ЭМСайдын 2019оны 12сарын 30 ны өдрийн А/611 дугаар тушаалын арван нэгдүгээр хавсралт маягт-10

РД

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ХУУДАС**

Эмнэлгийн нэр

Олгосон 2025 он 6 сар 03 өдөр Дугаар

Эцэг/эх/-ийн нэр Нэр Нас 38

Хүйс(зүр) эр, эм

Зорилго(Зур) ажилд орох, суралцах, гэр бүл болох, жолоо барих эрх авах, бусад

| № | Хийсэн шинжилгээ: Үзлэг | Онош дүгнэлт | Он, сар өдөр | Эмчийн гарын үсэг /тамга/ |
|---|---|---|---|---|
| 1 | Дотор | [illegible] | [illegible] | [illegible] |
| 2 | Мэдрэл | [illegible] | [illegible] | [illegible] |
| 3 | Чих, хамар, хоолой | [illegible] | [illegible] | [illegible] |
| 4 | Нүд | [illegible] | [illegible] | [illegible] |
| 5 | Шүд | [illegible] | [illegible] | [illegible] |
| 6 | Мэс засал | [illegible] | [illegible] | [illegible] |
| 7 | Эмэгтэйчүүд | [illegible] | [illegible] | [illegible] |
| 8 | Зүрх, судас | [illegible] | [illegible] | [illegible] |
| 9 | Сүрьеэ | [illegible] | [illegible] | [illegible] |
| 10 | Арьс, харшил | [illegible] | [illegible] | [illegible] |
| 11 | Халдварт | [illegible] | [illegible] | [illegible] |
| 12 | Сэтгэц мэдрэл | [illegible] | [illegible] | [illegible] |
| 13 | Гэмтэл согог | [illegible] | [illegible] | [illegible] |
| 14 | БЗДХӨ | [illegible] | [illegible] | [illegible] |

Ерөнхий эмч (эмнэлгийн эрхлэгч, орлогч)-ийн дүгнэлт шийдвэр:

Дүгнэлт, шийдвэр гаргасан он 06 сар өдөр

Амбулаторийн эрхлэгч

(ТАМГА)

ЭМСайдын 2019оны 12сарын 30 ны өдрийн А/611 дугаар тушаалын арван нэгдүгээр хавсралт маягт-10

РД

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ХУУДАС**

Эмнэлгийн нэр

Олгосон 2025 он 06 сар 03 өдөр Дугаар

Эцэг/эх/-ийн нэр Нэр Нас 41

Хүйс(зүр) эр, эм

Зорилго(Зур) ажилд орох, суралцах, гэр бүл болох, жолоо барих эрх авах, бусад

| № | Хийсэн шинжилгээ: Үзлэг | Онош дүгнэлт | Он, сар өдөр | Эмчийн гарын үсэг /тамга/ |
|---|---|---|---|---|
| 1 | Дотор | [illegible] | [illegible] | [illegible] |
| 2 | Мэдрэл | [illegible] | [illegible] | [illegible] |
| 3 | Чих, хамар, хоолой | [illegible] | [illegible] | [illegible] |
| 4 | Нүд | [illegible] | [illegible] | [illegible] |
| 5 | Шүд | [illegible] | [illegible] | [illegible] |
| 6 | Мэс засал | [illegible] | [illegible] | [illegible] |
| 7 | Эмэгтэйчүүд | [illegible] | [illegible] | [illegible] |
| 8 | Зүрх, судас | [illegible] | [illegible] | [illegible] |
| 9 | Сүрьеэ | [illegible] | [illegible] | [illegible] |
| 10 | Арьс, харшил | [illegible] | [illegible] | [illegible] |
| 11 | Халдварт | [illegible] | [illegible] | [illegible] |
| 12 | Сэтгэц мэдрэл | [illegible] | [illegible] | [illegible] |
| 13 | Гэмтэл согог | [illegible] | [illegible] | [illegible] |
| 14 | БЗДХӨ | [illegible] | [illegible] | [illegible] |

Ерөнхий эмч (эмнэлгийн эрхлэгч, орлогч)-ийн дүгнэлт шийдвэр:

Дүгнэлт, шийдвэр гаргасан он 06 сар 04 өдөр

Амбулаторийн эрхлэгч

(ТАМГА)








**Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал**

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулахад 49,793.0 мян.төгрөгийг зарцуулсан байна.

<table>
<tr><th>№</th><th>Байгаль орчны менежментийн төлөвлөгөө</th><th>2025 /Мян.төг/</th><th>Байгаль хамгаалах зардал</th></tr>
<tr><td>1</td><td>Тэрбум үндэсний хөдөлгөөнд нэгдэж, мод тарих, орчны ногоон байгууламж</td><td>30,525.0</td><td rowspan="7">Тухайн жилийн Байгаль хамгаалах Нийт зардлын 50-ийг БОНХЯ-ны байгаль хамгаалах, нөхөн сэргээх үүргийн барьцаа дансанд байршуулсан.<br><br>ГОЛОМТ БАНК<br>ТӨЛБӨРИЙН БАРИМТ / APPLICATION FOR REMITTANCE<br>Он сар өдөр: 2024 12 27<br>Дүн / Amount: =17,946,050.00=<br>Үсгээр / In words: (АРВАН ДОЛООН САЯ ЕСӨН ЗУУН ДӨЧИН ЗУРГААН МЯНГА ТАВИН ТӨГРӨГ)<br>Мөнгөний нэгж / Currency: MNT ✓ USD Бусад<br>ХЭНЭЭС / FROM<br>Дансны нэр / Account name: САЙНСАЙХАН КОНСАЛТИНГ СЕРВИС ХХК<br>Дансны дугаар / Account No<br>IBAN: MN15001500 1245117717<br>Төлбөрийн зориулалт / Details of payment: ХОС ХӨЛӨГ 2025 БАЙГАЛЬ ОРЧНЫ БАРЬЦАА<br>Гарын үсэг / Signature 1st 2nd<br>Тамга / Stamp<br>ХЭНД / TO<br>Банкны нэр / Bank name<br>Дансны нэр / Account name: ТӨРИЙН САН<br>Дансны дугаар / Account No<br>IBAN: 100220552401<br>ЗӨВХӨН БАНКНЫ ХЭРЭГЦЭЭНД / FOR BANK USE ONLY<br>ХҮА / TELLER<br>Хянасан / Verified by:<br>Он / сар / өдөр: 2024 12 27 / YYYY / MM / DD<br>ТЭМДЭГЛЭЛ / NOTE:<br>Шилжүүлэх данс<br>Хүлээн авах данс<br>Хүлээн авах дансны нэр<br>Хүлээн авагчийн банк<br>Мөнгөн дүн</td></tr>
<tr><td>2</td><td>Агаар орчныг хамгаалах арга хэмжээ</td><td>1,200.0</td></tr>
<tr><td>3</td><td>Газрын гадарга, хөрсөн орчныг хамгаалах арга хэмжээ</td><td>5,518.0</td></tr>
<tr><td>4</td><td>Усан орчныг хамгаалах</td><td>1,640.0</td></tr>
<tr><td>5</td><td>Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө</td><td>1,000.0</td></tr>
<tr><td>6</td><td>Удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ</td><td>9,910.0</td></tr>
<tr><td></td><td>Байгаль хамгаалах нийт зардал</td><td>49,793.0</td></tr>
</table>

Бусад ажил: Нийгмийн хариуцлагын хүрээнд Татварын газрын гадна авто зогсоол хийж гүйцэтгэсэн.








Хүлэмжийн ногоо тариалсан.





## ДҮГНЭЛТ

“Хос хөлөг” ХХК-ийн хэрэгжүүлж буй Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутагт байрлах “Төмөр замын ачиж буулгах терминал”-ийн төсөл нь Монгол Улсын байгаль орчны холбогдох хууль, дүрэм, журам, стандартаар тавигдах шаардлага, хүлээсэн үүргийн биелэлт 90 хувьтай хээргжүүлсэн.